



Ил захидал

Монгол улсын элчин сайд
Балдоржийн Даваадорж
Диецгенштрассе 31
13156 Берлин хот.

18.02.2014

Эрхэм хүндэт элчин сайд танаа,

„Гал үндэстэн“ холбооны гишүүн Ц. Мөнхбаяр болон бусад гишүүдэд тус бүр 21 жил 6 сарын хорих ял оноосон мэдээг бид цочирдон хүлээж авлаа. Аль ч ардчилсан улс оронд ижил төстэй хэрэг үйлдэхэд ийм хатуу ял шийтгэл ногдуулж байсан удаа үгүй билээ.

2013 оны 9 сарын 16- ны үйл явдлын улмаас учирсан гарз хохирол үгүй, гэмтэж шархдсан хохирогч байхгүй. Байгаль хамгаалагчид буу шийдмээ бусдын эсрэг хэрэглэх зорилгоор авчраагүй гэдгээ ч мэдэгдсэн. Бидэнд байгаа мэдээллээр буун дуу тэднийг баривчлагдсаны дараа гарчээ.

2013 оны 9 сарын 16 -ны тэдний үйлдэл нь ээлжит бус чуулган зарласан Их Хуралын анхаарлыг татах гэсэн Монголын байгаль хамгаалагчдын сүүлчийн оролдлого байв. 2011 оны хавар ч мөн адил тэд хамгаалан тэмцэж буй асуудалдаа олон нийтийн анхаарлыг хандуулах гэсэндээ Төрийн Ордон руу нум сумаар харваж байсан. Монголчуудтай олон жилийн туршид дотно нөхөрлөж ирсэн Германчууд бид цаашид үйл явдал хэрхэн өрнөхийг туйлын анхааралтай ажиглах болно гэдгийг Элчин сайд та Монгол улсын Засгийн Газарт уламжилж өгнө үү?

9 сарын 16-ны үйлдэл нь “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулинд өөрчлөлт оруулвал байгаль орчинд учирсан гарз хохирол дахин нэмэгдэх аюултай гэсэн тэдний зовнилоос үүдсэн. Энэ хууль бол Гал Үндэстэн Холбооныхны олон жилийн тэмцлийн үр дүн билээ. Тус хуулийг батлахад өнөөдөр ялтан болж шийтгэгдсэн хүмүүс маш чухал үүрэг гүйцэтгэсэн. Ц. Мөнхбаяр бол „Ногоон – Нобел” гэгдэх Голдманы байгаль хамгаалах ариун үйлсийн шагналтан.

Энэхүү хууль батлагдсанаар зарим уурхай хаагдсан. Гэвч олноор олгогдсон лицензийн тоо болон явуулж байгаа бодлогын чиг хандлага эсрэг байр суурийг харуулж байна. Үүний нэг тод жишээ нь Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэр дээр УРАН олборлох тухай 2013 оны намар Францын төрийн эзэмшлийн Арева компанитай хийсэн гэрээ юм. Арева олон жилийн туршид туршилтын өрөмдлөг хийсний улмаас тус суманд жил ирэх тусам ургийн гажигтай төл гарах нь нэмэгдэж, мал сүрэг нь олноороо хордож үхсээр байхад тэр гэрээг үзэглэсэн. Төл малын гажигтай төрөх, мал хордох нь туршилтын өрөмдлөгийн үйл ажиллагаанаас үүдэн ялгарсан цацраг идэвхит болон бусад хорт бодисуудаас шалтгаалсан байх магадлал өндөр. Мөн Ховд аймгийн Мянгад суманд ургийн гажигтай хүүхдүүд төрж байгаа ч мөн цацраг идэвхит ба хорт бодисуудтай холбоотой байх хардлага төрүүлж байгаа.



